Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын даргын 2025 оны ...07... сарын 10-ны өдрийн ...... дугаартай албан бичгийн хавсралт

# НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ "АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ"-НИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулах хөрөнгө мян/төг | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | 1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг:<br>а/байгууллагын албан ёсны цахим хуудас;<br>б/сошиал сувгууд;<br>в/дотоод сүлжээ;<br>г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл;<br>д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц;<br>е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх; | -Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх;<br>-Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх;<br>-Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших;<br>-Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | Жилдээ | Сар бүр цахим хуудсанд байршуулах | - | АТГ-аас бэлтгэсэн зурагт хуудсыг байгууллагын албан ёсны фэйсбүүкийн цахим хуудас болон https://aprd.ub.gov.mn вэбсайтад, улаанбаатар цахим бүртгэлийн системд тус тус байршуулж нийт давхардсан тоогоор 400 гаруй иргэнд хүрсэн байна. Мөн байгууллагын мэдээллийн самбарт АТГ-аас бэлтгэн гаргасан " Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн талаар гомдол гаргах, Иргэн та Авлигын эсрэг юу хийж чадах вэ?" брошурыг нийт албан хаагчдад танилцуулж байршуулсан. | 100 |
| | | 1.2.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан | -Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт | Жилдээ | 2 өдөрлөг, 1 аян | | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон олон улсын стандарт, баталгаажуулалтын итгэмжлэгдсэн байгууллага болох "SFCS" ХХК-тай | Галаа |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх;<br>-Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх;<br>-Хамтран ажилласан байгууллага, хүний тоо;<br>-Үр дүнг тооцсон байх. | | | | хамтран нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2016 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцоо стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн 2025 оны 02 дугаар сарын 18-ний өдөр "Баталгаажуулалтын гэрчилгээ"-гээ гардаж авсан болно. Үүнтэй холбогдуулан Газрын даргын тушаалаар "Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | |
| | | 1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах | -Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх;<br>-Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх;<br>-Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх;<br>-Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | Сар бүр | 1200 ш гарын авлага тараах | | АТГ-аас бэлтгэсэн зурагт хуудсыг байгууллагын албан ёсны Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар фэйсбүүкийн цахим хуудсад https://aprd.ub.gov.mn вэбсайтад, сурталчилгааны самбарт мөн АТГ-аас бэлтгэн гаргасан "Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн талаар гомдол гаргах, Иргэн та Авлигын эсрэг юу хийж чадах вэ?" брошурыг нийт албан хаагчдад танилцуулж, байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан. Нийт давхардсан тоогоор 400 гаруй иргэнд хүрсэн байна. "Авилгын эсрэг нэгдье" стикерийг хэлтсүүдийн өрөө, гарах орох хэсэгт байршуулан урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол хэрэгжүүлж байна.<br>Цаашид байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном, гарын авлага, хэвлэмэл материал зэрэгт | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна. | |
| | | 1.4.Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх | -Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх;<br>-Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх;<br>-Олон нийтэд түгээсэн байх. | 2, 3 дугаар улиралд | 12-оос доошгүй | | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2 видео контентыг байгууллагын албан ёсны пэйж хуудас, болон вебсайтад байршуулж нийт 250 гаруй иргэд олон нийтэд хүрсэн. | 100 |
| 2. | 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх | 2.1."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх | -Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх;<br>-Сонгосон чиглэлд олон нийтийг хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх;<br>-Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах;<br>-Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх. | Жилдээ | 1-ээс доошгүй | | Тус газар нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох ажлын хүрээнд байгууллагын албан ёсны сайтын үндсэн 7 цэсийг ажиллуулж байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хагас жилийн байдлаар нийт 65 мэдээллийг хуулийн хугацаанд shilendans.gov.mn цахим сайтад байршуулан мэдээлэлийн ил тод байдлыг хانган ажиллаж байна.<br>Мөн нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.3 дахь хэсгийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэгжилтийг хангах ажлын хүрээн газрын даргын 2025 оны А/29 дугаартай "shilen.gov.mn" системд цаг тухай бүр байршуулах админ эрх олгох тухай тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсэг нь 5 бүлгийн 126 асуумжийн хүрээнд 2025 оны I улирлын тайлан мэдээг shilen.gov.mn сайтад байршуулж 50.97 хувиар үнэлэгдсэн байна. 2025 оны II дугаар улирлын мэдээллийг 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор байршуулахаар бэлтгэн ажиллаж байна.<br>Төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын албан ёсны цахим хуудасны үндсэн 7 цэсэнд чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа болон иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийг ил тод, нээлттэй хүргэх хүрээнд нийт 45 мэдээ, 10 постер, 5 зар болон холбогдох төлөвлөгөө, тайлангийн мэдээллийг цаг тухай бүрт байршуулан олон нийтэд мэдээлэл түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна. | |
| | | 2.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх | -Салбарт бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх;<br>-Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, | Жилдээ | 4-өөс доошгүй | | Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран "Авлигын ашиг сонирхолоос урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл олгох, хууль бус давуу байдал гэж юуг ойлгох " зэрэг сэдвийн хүрээнд нийт 30 албан хаагчдыг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх;<br>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх. | | | | хамруулан сургалт зохион байгуулсан болно.<br>2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газартай хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сургалтад нийт 20 албан хаагчид оролцож асуулт хариулт, кейс дээр дасгал ажил хийсэн. Мөн авлигатай тэмцэх газартай хамтран 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр "Авлигын ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, хууль эрхзүйн мэдлэг мэдээлэл олгох" сэдэвт сургалт байгууллагын нийт 25 албан хаагчдыг хамруулсан. | |
| | | 2.3.Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах | -2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх;<br>-Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах;<br>-Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх. | Жилдээ | 12-оос доошгүй нээлттэй мэдээлэх | | 2025 оны байгууллагын урсгал төсөв болон Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 10-н төсөл арга хэмжээг 62,927,99,093 төгрөгөөр хийж хэрэгжүүлэхээр Tender.gov.mn цахим системд төлөвлөгөөг баталгаажуулан, нийт 5 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үр дүнг цахим системд тухай бүр тайлагнан ажилласан. Цаашид хийж хэрэгжүүлэх 5 төсөл, арга хэмжээ хүлээгдэж байна. | 100 |
| | | 2.4.Байгууллагуудын үйл ажиллагаа, | -Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний | Жилдээ | 2-оос доошгүй | | 2025 оны хагас жилийн байдлаар нийт 171 өргөдөл, гомдол хүлээн авсан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших | хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах;<br>-Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших;<br>-Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх. | | | байна. Үүнээс иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс 121 өргөдөл ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн 118, хугацаа хэтэрсэн 0 өргөдөл гомдол байна. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 9 цаг 34 минут. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас агаар болон орчны хэмжилт, хяналт шалгалт хийлгэх хүсэлт, гомдлууд ирүүлж байгаатай холбогдуулан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа өндөр байгаа бөгөөд дээж лабораторид хүргүүлэх, үр дүн мэдээ гарах хугацаатай холбогдуулан шийдвэрлэлтийн явц удаашрах нөхцөл үүсэж байна. Нийт өргөдөл, гомдлын дийлэнх хувь нь Агаарын бохирдлын тухай 59,66%, Хог хаягдал шатаах, орчны эвгүй үнэр, бохирдлын тухай 21,85%, Шахмал болон боловсруулсан түлшний тухай 6,72% байна. 11-11 төвөөс ирүүлсэн өргөдөл гомдлыг хагас жилийн байдлаар зөрчилгүй хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. | |
| | | 2.5.Улс, орон нутаг, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгох | -MNS 7023:2023 "Мэдээллийн самбар"-т тавигдах шаардлага бүхий үндэсний стандартын хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах. | Жилдээ | Тухай бүр | Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор тус газар нь олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагатай хамтран "Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлж тайлан мэдээг тухай бүр байгууллагын албан ёсны сайтад иргэд олон нийтэд нээлттэй байдлаар байршуулж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Япон Улсын элчин сайдын яаманд 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 04/486 тоот албан бичгээр Япон Улсын буцалтгүй тусламж "Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-өөр агаарын чанарын хэмжилтийн суурин харуулын тоног төхөөрөмж шинэчлэх талаар санал хүргүүлсэн. 2025 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Япон Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хооронд нот бичигт гарын үсэг зуралцан 275 сая иенийн буцалтгүй тусламжаар Агаарын бохирдол хэмжих багаж тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл батлагдсан. Энэхүү ажлын хүрээнд Японы Олон улсын хамтын ажиллагааны систем (JICS)-байгууллагын төлөөлөгч нар худалдан авалтад бэлтгэхийн тулд 2025 оны 6-р сарын 17-оос 06 дугаар сарын 19-ны өдрүүдэд 6 суурин харуулын тоног төхөөрөмж, тэдгээрийн хэрхэн ажиллаж байгааг шалгах, одоо байгаа сүлжээг шалгаж, төслийн өгөгдөл дамжуулах хүрээг ярилцах нийлүүлэх тоног төхөөрөмжийн жагсаалт гаргах, хаягдал утааны хэмжилтийн лабораторид ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн одоогийн нөхцөл байдалтай танилцах нийлүүлэх багаж, тоног төхөөрөмжийн жагсаалт гаргах чиглэлээр Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын удирдлага болон холбогдох мэргэжилтэнүүдтэй уулзаж, цаашид хэрэгжих төслийн талаар санал солилцон ажиллаж байна. | |
| 3. | 3.Авлига, ашиг | 3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах | -Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар | Жилдээ | 4-оос доошгүй | | Байгууллагын албан ёсны сайтын санал хүсэлтийн цонхонд цахим үйлчилгээний | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах;<br>-Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх;<br>-Хэрэгжилтийг тайлагнах. | | | | чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авч ажиллаж байна.<br><br>Байгууллагын албан ёсны вебсайтын Хууль эрхзүй дэд цэсэд Монгол Улсын авилгатай тэмцэх газраас эрхлэн гаргасан "Мэдүүлэг гаргагчдад зориулсан гарын авлага"-ыг иргэд олон нийтэд нээлттэй байдлаар байршуулан ажиллаж байна. | |
| | | 3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | -Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших;<br>-Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх;<br>-Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх. | Жилдээ | Тухай бүр | | Байгууллагын дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хийх 2025 оны төлөвлөгөөний дагуу тухай бүр удирдамж боловсруулан, төлөвлөгөөт хяналт шалгалт 2 удаа хийж, дүгнэлтийг газрын даргад танилцуулан цаашид үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж боловсруулж хүргүүлсэн болно.<br><br>Байгууллагын 2024 оны жилийн эцэст хийгдсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох хуулийн байгууллагад шалгуулахаар хүргүүлж холбогдох тайлбар мэдүүлгийг өгч ажиллаж байна.<br><br>Мөн Төрийн аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, албан шаардлагад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж дүгнэлтийг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулан дахин давтагдах эрсдлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. | Галаа |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.3.Нийслэлийн хэмжээнд Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг тусгасан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | | | 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 заалт, 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Цаашид авилгын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлж, Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа гаргуулж ашиг сонирхлоос ангид байлгах чиглэлээр сургалт зохион байгуулах, Үндэсний Аудитын газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын шалгалтаар илэрдэг санхүүгийн зөрчил дутагдалыг цаашид гаргахгүй байхад чиглэсэн үр дүнтэй ажил зохион байгуулах, авилгын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох ажлуудыг төлөвлөн ажиллаж байна. | 100 |
| | | 3.6.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийх | -Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;<br>-Дүгнэлт зөвлөмж гаргасан байх. | Жилдээ | | | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд Засгийн газрын 43 дугаар тогтоолын хүрээнд хагас жил болон жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гарган ажиллаж байна.<br><br>2025 оны эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын нийт 11 удаагийн биелэлт, Монгол улсын сайд, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга болон Нийслэлийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан "Хуульд заасан төрийн зарим чиг үүргийг нийслэлд төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ"-ний 2025 оны хагас жилийн биелэлт, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын байгаль орчин, уур амьсгалын Өөрчлөлтийн салбарт хамтран ажиллах гэрээний 2025 оны эхний хагас жилийн биелэлт, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан "Хариуцлагын гэрээ"-ний 2025 оны эхний хагас жилийн биелэлт, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт, "Нийслэл хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" -ийн 2025 оны хагас жилийн биелэлт, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын 2025 оны хагас жилийн гүйцэтгэлийн биелэлтийг тус тус гаргаж НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст ERP цахим системийн хяналт шинжилгээ үнэлгээ цэсэд болон цахим холбоосоор хугацаанд нь тогтмол тайлагнан ажиллаж байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.7.Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулах | -Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулж, 7 хоног тутам мэдээ, мэдээллийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудад танилцуулах. | Жилдээ | | | 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 06 дугаар сарын 19-ны байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 176 өргөдөл, гомдол ирүүлснээс хугацаанд нь шийдвэрлэсэн 171, судлагдаж буй 5, хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 1, Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 3 цаг 3 минут, 2025 оны хагас жилд зөрчлийн тоон үзүүлэлтийг бууруулж хуулийн хугацаанд хянан шийдвэрлэхээр ажиллаж шилжин ирсэн өргөдөл, гомдлыг холбогдох албан тушаалтанд шуурхай шилжүүлж байгууллагын дотоод сүлжээнд тогтмол мэдээлэл хүргүүлэн хяналт тавьж ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд шилжин ирсэн өргөдөл, гомдлын хүснэгтэн тайлан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, дүн шинжилгээний хамтаар долоо хоног бүрийн пүрэв гарагт Нийслэлийн Засаг даргын тамгын газарт нийт 32 албан бичгээр улирлын болон долон хоногийн тайлан мэдээг хүргүүлэн ажилласан. | 100 |
| | | 3.8.Нийслэлийн удирдах ажилтны шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгавар, Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах | -Засаг даргын захирамж, ажлын хэсэг, албан тушаалтанд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцсон байх. | Жилдээ | | | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг нийт 11 удаа гаргаж, НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ulaanbaatar.mn сайтад болон ERP цахим системийн хяналт шинжилгээ үнэлгээ цэсэд хугацаанд нь тогтмол тайлагнан ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.9.Худалдан авах ажиллагааны А3 сургалтад хамрагдах албан хаагчийн тоог нэмэгдүүлэх | -Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо. | Жилдээ | 100 | | Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А3 сертификат олгох сургалтад 2025 оны 02 дугаар сарын 07-08-ний өдрийн хооронд 5, 2025 оны 03 дугаар сарын 15-16-ний өдөр 8, нийт 13 албан хаагчдыг хамруулсан. | 100 |
| | | 3.10.Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах | -Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг хэрэгжилтийг хангаж, төрийн сангийн үйл ажиллагаанд хяналтыг тогтмол хийж хэвшсэн байх. | Жилдээ | | | 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 24/33 дугаар тогтоолоор 2025 онд нийт 58,443,946,000 төгрөгийн төсөв батлагдсан.<br><br>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын хүрээнд төсвийн орлого, түүний зарцуулалт, хуваарилалтыг тухай бүр байршуулж олон нийтэд мэдээлж ажиллаж байна. Мөн Shilendans.gov.mn сайтад сар бүр болон тухай бүр оруулах мэдээлэлд Байгууллагын бүтэц, орон тоо, хөрөнгө, зардал гаргах тушаал шийдвэрүүдийг тухай бүр цахим санд оруулж байна.<br><br>Байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд Төсвийн гүйцэтгэлийн сар, улирлын мэдээг сар бүр гаргаж Санхүү,Төрийн сангийн газарт хүргүүлсэн ажиллаж байна. | 100 |
| | | 3.11.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах | -Нийслэлийн удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалт зохион байгуулсан байх;<br>-Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулсан | Жилдээ | | - | Авлигатай тэмцэх газартай хамтран 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр "Авлигын ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, хууль эрхзүйн мэдлэг мэдээлэл олгох" сэдэвт сургалт байгууллагын нийт 25 албан хаагчдыг хамруулсан. Мөн 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдөр Нийслэлийн Засаг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сургалт зохион байгуулсан байх;<br>-Нийслэлийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн албан хаагч нарт зориулсан сургалт зохион байгуулсан байх;<br>-Иргэний нийгмийн байгууллага (Иргэн, сонирхлын бүлэг, ТББ, мэргэжлийн холбоо г.м)-д чиглэсэн сургалт зохион байгуулсан байх;<br>-Хувийн хэвшилд зориулсан сургалт зохион байгуулсан байх. | | | | даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газартай хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сургалтад нийт 20 албан хаагчид оролцож асуулт хариулт, кейс дээр дасгал ажил хийсэн.<br><br>PDD Consulting Institute" мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран "Байгууллагын соёл, ёс зүйн хэм хэмжээ, ажилтнуудын харилцаа хандлагыг сайжруулах, багийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, удирдлагын багийн гүйцэтгэлийн үнэлгээний манлайлал зэрэг нийт 4 сэдвийн хүрээнд 12 цагийн цуврал сургалтыг шат дараатайгаар зохион байгуулсан.<br><br>Удирдлагын академиас зохион байгуулж буй хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшүүлэх багц сургалт болох "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх" нь "Төрийн байгууллагын стратеги төлөвлөлт, "Дизайн сэтгэлгээ", "Байгууллагын зэрэг соёлыг бүрдүүлэх" 4 сэдэвт сургалтад нийт 8 албан хаагч хамрагдаж сертификат гардан авсан болно.<br><br>Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд Нийслэлийн бүсийн зөвлөгөөнийг 2025.05.28-29-ний "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэглээ" сэдэвт хэлэлцүүлэгт 1. "Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэглээ" сэдэвт хэлэлцүүлэгт 2. "Төрийн албан хаагч | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эмэгтэйчүүдийн карьер хөгжлийг дэмжих, төрийн албан дахь удирдах түвшний жендэр" хэлэлцүүлэгт 1, нийт 4 албан хаагчид оролцсон байна. | |
| | | 3.12.Төрийн болон албаны нууцын тухай, хадгалалт хамгаалалт талаар сургалт зохион байгуулах | -Нийслэлийн удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалт зохион байгуулсан байх;<br>-Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ-ын албан хаагчдад зориулсан зохион байгуулсан байх. | Жилдээ | 2-оос доошгүй | | Тус газраас 2025 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/46 дугаартай албан бичгээр Төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т заасны дагуу тус байгууллагын нууцын ажилтнаар Архив бичиг хэргийн эрхлэгч Х.Үүрцайхыг томилох саналыг Тагнуулын Ерөнхий газарт хүргүүлсэн.<br><br>Уг бичгийн дагуу Тагнуулын Ерөнхий газрын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 09/200 дугаартай албан бичгээр зөвшөөрөл ирүүлсэн тул Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн Б/17 дугаар тушаалаар архив, бичиг хэргийн эрхлэгч Х.Үүрцайхыг байгууллагын нууцын ажилтнаар томилсон. | 100 |

---oOo---